

**Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2023 оны
Худалдан авах ажиллагааны тайлан**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12-р сарын 19-ний өдрийн 583 тоот тогтоолын хавсралтаар батлагдсаны дагуу компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2022 оны 12-р сарын 21-ны өдрийн 89/02 тоот тогтоолоор батлагдсан байна.

2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь нийт 55 багц худалдан авалтыг 17,550,6 сая төгрөгөөр, ашиглалтын зардалд тусгах бараа, ажил, үйлчилгээний 6 багц худалдан авалтыг 980,0 сая төгрөгөөр зохион байгуулахаар баталсан байна. Үүний дагуу жилийн эцсийн байдлаар

1. Хөрөнгө оруулалтын дагуу төлөвлөгдсөн 55 багц худалдан авалтаас 50 багц худалдан авалтыг 12,841,9 сая төгрөгөөр,
2. Ашиглалтын зардалд тусгах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгдсөн 6 багц худалдан авалтаас 5 багц худалдан авалтыг 788,8 сая төгрөгөөр тус тус амжилттай зохион байгуулж гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. /Худалдан авах ажиллагааны задаргааг хавсаргав/

Хавсралт

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ	Төсөл арга хэмжээ	Төлөвлөгөө	2023 оны жилийн эцсийн байдлаарх тендер зарласан	Гэрээ хийгдсэн дүн	Хэрэгжээгүй ажлууд	Гүйцэтгэлийн хэмнэлт			
Хөрөнгө оруулалт										
1	Сувагчлал, худаг, кабель шугам, шилэн кабелийн өргөтгөл	13	1,032,141	13	1,032,141	11	765,983	2	181,481	84,678
2	Цамхаг	2	1,280,952	2	1,280,952	2	1,256,542	-	-	24,410
3	Зай тэжээлийн шинэчлэл, хөргөлтийн тоног төхөөрөмж	5	1,476,725	5	1,476,725	5	1,440,494	-	-	36,231
4	Салбарын технологийн барилга	15	1,930,039	15	1,930,039	13	1,557,085	2	296,282	76,672
5	Дамжуулах сүлжээний сайжруулалт	6	4,757,946	5	962,860	5	938,407	1	3,795,086	24,453
6	Өгөгдлийн сүлжээний тоног төхөөрөмж	2	922,406	2	922,406	2	914,927	-	-	7,478
7	Дамжуулах болон өгөгдлийн сүлжээний нөөц төвийн тоног төхөөрөмж	2	2,051,278	2	2,051,278	2	1,937,178	-	-	114,100
8	Технологийн багаж, техник хэрэгсэл	7	3,604,956	7	3,604,956	7	3,546,539	-	-	58,417
9	Програм хангамж	3	494,169	3	494,169	3	484,826	-	-	9,343
	Нийт дүн	55	17,550,612	54	13,755,526	50	12,841,981	5	4,272,849	435,782
Ашиглалтын зардалд тусгах бараа, ажил, үйлчилгээ										
1	Бараа, ажил, үйлчилгээ	6	980,011	6	980,011	5	788,835	1	102,946	88,230
	Нийт дүн									
	Дүн	61	18,530,623	60	14,735,537	55	13,630,816	6	4,375,794	524,012

Компанийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бараа, ажил, үйлчилгээны худалдан авалт

Хөрөнгө оруулалт

1-р бүлэг: Орон нутгийн салбарын технологийн барилга бүлгийн 13 багц ажлаас 11 багц ажил хэрэгжсэн. Дараах 2 ажил Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан боловч нэг ч тендер ирээгүйн улмаас гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа амжилтгүй болсон болно. Үүнд:

- МХС/202312007 тоот ХУД. АТС34 ХШ404. Монгол дээд сургуулийн зүүн талд Р-С 2-16 худгаас Р-С 21-2 худаг хооронд сувагчлалын өргөтгөл хийх ажлыг 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт зааснаар нэг ч тендер ирээгүй. Үүний дагуу тус хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-ийн дагуу Шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн боловч дахин санал ирээгүй,
- МХС/202312008 тоот БГД. АТС36 ХШ663. 25-р эмийн сангийн урд талд Р-С 36-12-1 худгаас Р-С 2-14 худаг хооронд сувагчлалын өргөтгөл хийх харьцуулалтын тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 3 удаа зарлахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт заасан нэг ч тендер ирээгүй

2-р бүлэг: Цамхаг бүлгийн 2 багц ажил хэрэгжсэн болно.

3-р бүлэг: Зай тэжээлийн шинэчлэл, хөргөлтийн тоног төхөөрөмж бүлгийн 5 ажил бүрэн хэрэгжсэн болно.

4-р бүлэг: Салбарын технологийн барилга бүлгийн 15 багц ажлаас 13 багц ажил хэрэгжсэн. Дараах 2 ажил хэрэгжээгүй болно. Үүнд:

- МХС/202312025 тоот Орхон аймгийн төв байрны гадна, дотор бохирын шугамын засвар гүйцэтгэх харьцуулалтын тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 4 удаа зарлахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт заасан нэг ч тендер ирээгүй
- МХС/202312031 тоот УБ хот Баянчандмань дахь сургалтын төвийн өргөтгөл хийх ажлыг 2024 оны төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлэхээр

5-р бүлэг: Дамжуулах сүлжээний сайжруулалт бүлгийн 6 багц ажлаас 5 багц ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. “Монгол Улсын төрийн өмчийн шилэн кабелийн үндсэн сүлжээний хүртээмж, чанарыг сайжруулах, үндэсний радио долгионы хяналт, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалт”-ыг хэрэгжүүлэх ажил хэрэгжиж эхлээгүй учраас төслийн 5 хувь (2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс шилжиж ирсэн) болох 3,795,0 сая төгрөгийн санхүүжилт нь манай компаниас гараагүй болно.

6-р бүлэг : Өгөгдлийн сүлжээний тоног төхөөрөмж бүлгийн 2 багц ажил хэрэгжсэн болно.

7-р бүлэг: Дамжуулах болон өгөгдлийн сүлжээний нөөц төвийн тоног төхөөрөмж бүлгийн 2 багц ажил хэрэгжсэн болно.

8-р бүлэг: Дамжуулах болон өгөгдлийн сүлжээний нөөц төвийн тоног төхөөрөмж бүлгийн 7 багц ажлаас 7 багц ажил бүрэн хэрэгжсэн.

9-р бүлэг: Програм хангамж бүлгийн 3 багц ажил хэрэгжсэн болно.

Ашиглалтын зардалд тусгах бараа, ажил, үйлчилгээ

Ашиглалтын зардалд тусгах бараа, ажил, үйлчилгээ бүлгийн 6 багц ажлаас 5 багц ажил бүрэн хэрэгжиж дууссан ба МХС/202312060 тоот гэрээ Зай тажээлийн сэлбэг хэрэгсэл нийлүүлэх ажил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тххай хуулийн 30.1.1-ийн дагуу шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй байна.

Компанийн өдөр тутмын захиалгын дагуу худалдан авалт

Компанийн тасралтгүй үйл ажиллагаа, техникийн бэлэн байдлыг хангах зорилгоор газар хэлтсийн захиалгын дагуу бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулдаг болно. Худалдан авах ажиллагааны хэлтэс 2023 онд дараах нэр төрлийн дагуу ангилж худалдан авалт хийсэн байна

- Барилгын засвар
- Автомашины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл
- Холбооны тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл
- Цэвэрлэгээний материал
- Бичиг хэргийн бараа, материал
- Аж ахуйн бараа
- Хөдөлмөр хамгааллын бараа, материал

Компанийн ашиг орлого нэмэгдүүлэх

Компанийн ашиг орлого нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд зарлагдсан Эрчим хүчний яамнаас зарласан “Хөшгийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл, Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замаас зарласан “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлэх” төсөл, Диспетчерийн үндэсний төвөөс зарласан “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх” төсөлд тус тус цахим тендерт оролцон гэрээ байгуулахаар болсон байна.

Бусад ажил

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх,

- тайлагнах журамд заасан хугацааны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Монгол Улсын сангийн яаманд хүргүүлдэг болно.
2. Тухайн жилийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэлийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон шилэн дансны нэгдсэн системд тус тус байршуулж хөтөлдөг болно.
 3. Тухайн жилийн Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалт, гэрээ, өдөр тутмын худалдан авалтын баримт материалыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн аудитын байгууллага, Дотоод аудитын албанд тус тус шалгуулж үнэлгээ дүгнэлт авсан байна.
 4. Мөн худалдан авах ажиллагаатай холбогдох бүх материалиудыг хадгаламжийн нэгж болгон компанийн архив хариуцсан ажилтанд шилжүүлдэг болно.

Худалдан авах ажиллагааны хэлтэс